



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Хүрэлбаатарын БААСАНЖАРГАЛ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-02, Факс: 32-70-16
E-mail: baasanjargal@parliament.mn
<http://www.parliament.mn>

2026.03.17 № 41203/2616
танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА НЯМ-ОСОРЫН УЧРАЛ
ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Х.БААСАНЖАРГАЛ

Д.ГАНМАА

Г.ЛУВСАНЖАМЦ

С.ЭРДЭНЭБАТ

0000000042



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Хүрэлбаатарын БААСАНЖАРГАЛ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-02, Факс: 32-70-16
E-mail: baasanjargal@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.12.30 № 412-03/15 043
танай _____-ны № _____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Тов тогтоох тухай

Миний бие Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн нэг дэх хэсгийн 1, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д заасны дагуу бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар асуудлыг ардчилсан зарчмаар, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид хараат бусаар шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэн Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа, Г.Лувсанжамц, С.Эрдэнэбат нарын хамт Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулан холбогдох талуудаас санал авч ажилласан.

Иймд энэхүү хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн дагуу дээрх хуулийн төслийг өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгож өгөхийг танаас хүсье.

Хуулийн төсөл, түүний үзэл баримтлал, танилцуулгыг хавсаргав.

Хавсралт 19 хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Х.БААСАНЖАРГАЛ

0000000249

Хавсралт

БАТЛАВ.
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Х.БААСАНЖАРГАЛ

2025 оны 12 дугаар сарын 13

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.” гэж заасан. 2023 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөөр Улсын Их Хурлын гишүүдийн тоог нэмэгдүүлж 126 гишүүнтэй болсноор нийгмийн олон талт төлөөлөл бүхий парламент бүрдэх нөхцөл бий болсон. Ингэснээр ард түмний сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөллийн байгууллагад сонгогдон ажиллаж буй гишүүдийн хувьд өргөсөн тангарагтаа үнэнч байж, бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх шаардлага тэр хэрээр нэмэгдсэн гэж хэлж болно.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.3-т “гишүүний нэр хүнд, бүрэн эрхийг хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглах;”-ыг хориглосон бол Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1-т “Гишүүн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, улс төрийн үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх нөхцөлийг баримталж ажиллана.” гэжээ.

Түүнчлэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т “Албан тушаалтан албаны бүрэн эрхээ хувийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн зорилгод ашиглахгүй бөгөөд албан үүрэгт нь нөлөөлөхүйц аливаа харилцаанаас ангид байна.”, мөн зүйлийн 6.4-т “Албан тушаалтан ашиг сонирхлын зөрчилд орж болохуйц нөхцөл байдлыг мэдэгдэх, түүнээс татгалзах замаар урьдчилан сэргийлнэ.” гэж тус тус заасан. Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн Зорилт 2.4-т “Төрийн өндөр албан тушалатан, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтныг ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэсэн болно. Мөн Монгол Улсын нэгдэн орсон Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 5 дугаар зүйлийн 3-т “Оролцогч улс бүр авилгалаас урьдчилан сэргийлж, тэмцэхэд нийцэхүйц байдлыг тодорхойлох зорилгоор холбогдох эрх зүйн баримт бичиг болон захиргааны арга хэмжээнд тогтмол дүгнэлт хийж байхыг чармайна.” гэсэн болно.

Монгол Улсын хувьд Авилгын төсөөллийн индексээр сүүлийн 8 жилийн хугацаанд тогтмол оноо буурч, 2024 оны байдлаар 180 орноос 114-т эрэмблэгдэж байгаа бөгөөд төрийн нийтийн албан хаагч албан тушаалаа урвуулан ашиглаж

байгаа эсэх, хэсэг бүлгийнхэнд зориулж хууль батлагдаж байгаа эсэх, авилгын эсрэг хууль тогтоомж хэрэгжиж буй эсэх үзүүлэлтээр хангалтгүй үнэлэгдсэн хэвээр байна.

Парламент нийгмийн хөгжлийн үндсэн асуудлыг ардчилсан зарчмаар шуурхай шийдвэрлэхийн тулд өөрийн үйл ажиллагааныхаа үр өгөөжийг дээшлүүлэх, тухай бүр боловсронгуй болгож байх ёстой институци, төрийн эрх барих дээд байгууллагын хувьд бусад байгууллагын хувьд үлгэр жишээ байх учиртай. Иймд цаг үеийн хэрэгцээ, шаардлагыг тогтмол шинжлэн судлах, түүнд үндэслэн хууль тогтоомжийн төслийн санал боловсруулах урт хугацааны санах ой бүхий байнгын тогтолцоог бүрдүүлэх нь Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөнд туссан томоохон зорилт тул Улсын Их Хурлын гишүүн ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зохицуулалтыг илүү тодорхой болгож, Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хэрэглээг боловсронгуй болгох нь зүйтэй гэж үзэв.

1.2.Практик хэрэгцээ, шаардлага

1.Дэлхийн ихэнх улс орны парламент үйл ажиллагааны ил тод, “шилэн” байдлаа хангахын тулд өөрийн гишүүдийн ашиг сонирхлын мэдүүлэг, бүртгэлийг тогтмол хөтөлж хэвшсэн. Тухайлбал, ИБУИНВУ-ын парламентад Ашиг сонирхлын бүртгэл (Register of Interests) тогтмол хөтөлдөг бөгөөд тухайн чуулганаар хэлэлцэж буй асуудлын талаар гишүүдийн хийсэн мэдэгдэл, тухайн гишүүний цалин хөлс, шагнал, урамшуулал, гадаад, дотоод томилолтод зарцуулсан зардал зэргийн талаар тогтмол мэдээлж хэвшжээ. Евро парламент өөрийн гишүүдийн Санхүүгийн ашиг сонирхлын бүртгэл (Register of Members' Financial Interests)-ийг тогтмол хөтөлдөг бөгөөд уг бүртгэл парламентын албан ёсны вэб хуудаст нээлттэй байршдаг.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т “Хуульд ил тод, нээлттэй байхаар заасан, эсхүл хязгаарлалттай болон хаалттай мэдээлэлд хамаарахгүй мэдээллийг нээлттэй мэдээлэл гэж үзнэ.” гэсэн ба Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг нээлттэй байна.”, 25.2-д “Энэ хуулийн 24.1-д заасан байгууллага, албан тушаалтан иргэдийг албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэгтэй саадгүй танилцах боломжоор хангах үүрэгтэй.” гэж заасан.

Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т “Дараахь албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг тухайн оны 2 дугаар улиралд багтаан цахим мэдээллийн сүлжээнд байрлуулна.” гээд 14.1.2-т “Улсын Их Хурлын дарга, дэд дарга, гишүүн,” гэж заасан.

Иймд Улсын Их Хурлын гишүүдийн хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг, мөн тухайн хэлэлцэж байгаа асуудалтай шууд холбоотой үйл ажиллагааны үр дүнд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээд орлого олж байгаа, эсхүл бусад хэлбэрээр ашиг сонирхлын зөрчилтэй тухай гишүүний мэдэгдлийг Улсын Их Хурал өөрийн албан ёсны цахим хуудастаа нэгэн зэрэг нийтэлж, иргэдийн мэдэх эрхийг хангаж байх нь парламентын үйл ажиллагааны ил тод байдлыг хангахад эерэг үр нөлөөтэй гэж үзэв.

2.Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн дагуу гишүүн тодорхой асуудлаар ашиг сонирхлын зөрчилтэй бол хянан шалгах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орохыг хориглосон болно. Ашиг сонирхлын зөрчилтэй гишүүнд тавигдах энэхүү хязгаарлалтыг хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт мөн адил орохгүй байхаар зохицуулах нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.23-т “гишүүн хэлэлцэх гэж байгаа асуудалтай шууд холбоотой үйл ажиллагааны үр дүнд өөрөө болон гэр бүлийн гишүүд нь орлого олж байгаа, эсхүл бусад хэлбэрээр ашиг сонирхлын зөрчилтэй бол тухайн асуудлаар хэлэлцүүлэг, санал хураалтад оролцохоос татгалзах;” тухай гишүүний бүрэн эрхийг бодитой хэрэгжүүлэхэд дэмжлэг болно гэж үзэв.

3.Хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.10-т “Гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай шууд холбоотой үйл ажиллагааны үр дүнд өөрөө болон гэр бүлийн гишүүд нь орлого олж байгаа, эсхүл бусад хэлбэрээр ашиг сонирхлын зөрчилтэй бол энэ тухай хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдэж санал хураалтад оролцохгүй.” гэж тус тус заасан. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн 4.12-т “Хэлэлцэж байгаа асуудал нь ашиг сонирхлын зөрчил үүсэхээр бол гишүүн энэ тухай хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдэж, санал хураалтад оролцохоос сайн дураараа татгалзана.” гэсэн болно.

Дэлхийн ихэнх улсын парламентад хэлэлцэж буй асуудлын талаар **ашиг сонирхлын зөрчилтэй** тохиолдолд санал хураалтад оролцохгүй байх замаар тухайн асуудлаарх байр сууриа илэрхийлдэг жишиг түгээмэл байна. Энэхүү жишиг нь зөвхөн тухайн гишүүн өөрөө болон түүний гэр бүлийн гишүүдээр хязгаарлагдахгүйгээр эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, нэгдмэл сонирхолтой этгээдийг ч хамарч байна.

Гэвч өнгөрсөн хугацаанд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.10 дахь хэсгийн хэрэгжилт хангалтгүйн улмаас гишүүд ашиг сонирхлын зөрчилтэй асуудлыг чуулганы хуралдаанаар хэлэлцэх үед санал хураалтад оролцохгүй байх үүргээ санаатай болон санамсаргүй шалтгаанаар тухай бүр биелүүлж чадахгүй ирсэн байдаг.

Иймд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан шаардлагад одоогийн зохицуулалтыг нийцүүлж гишүүнийг зөвхөн өөрийг нь болон гэр бүлийн гишүүдээр нь хязгаарлахгүйгээр түүнтэй хамаарал бүхий этгээд буюу нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг хуулийн үйлчлэлд хамааруулах нь зүйтэй байна.

4.Авлигатай тэмцэх газраас гаргасан зөвлөмжид “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэх үүрэгтэй, эрх бүхий байгууллага, албан тушаалтан тухайн албан тушаалтны гаргасан ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүссэн талаарх тайлбар болон ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл, хувийн ашиг сонирхлын мэдүүлэгт үндэслэн тухайн албан үүргийг өөр албан тушаалтнаар гүйцэтгүүлэх эсэх шийдвэрийг нэн даруй бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргах бөгөөд шийдвэр

гаргаагүй бол ашиг сонирхлын зөрчилгүй гэж үзсэнд тооцно.” гэжээ.

Иймд чуулганы хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудалтай шууд холбоотой үйл ажиллагааны үр дүнд өөрөө болон хамаарал бүхий этгээд нь орлого олж байгаа, эсхүл бусад хэлбэрээр ашиг сонирхлын зөрчилтэй бол энэ тухай хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдэж санал хураалтад оролцохгүй байх үүргээ биелүүлэхэд нь хуралдаан даргалагчийн зүгээс зохих ёсны идэвхитэй үйлдэл хийх, гишүүний мэдэгдлийг албажуулах арга хэмжээ авах нь зөв байна.

5.Тухайн хэлэлцэж буй асуудлаар ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ мэдэгдэж санал хураалтад оролцоогүй гишүүн хуралдааны ирцдээ байх эсэх нь түүний бүрэн эрхийн асуудал хэдий ч ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ мэдэгдэж санал хураалтад оролцоогүй бөгөөд ирцээсээ гараагүй байгаа гишүүнийг “эсрэг” санал өгсөнд тооцсон тохиолдол гарч байв. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.11 дэх хэсэгт “Тухайн өдрийн хуралдаан эхлэхэд ирцэд бүртгүүлсэн гишүүн чөлөө аваагүй, хүндэтгэн үзэх болон энэ хуулийн 7.5-д заасан эсэргүүцэх шалтгаантайгаа мэдэгдэлгүй хуралдааныг орхиж гарсан, эсхүл бүртгэлээс гарсан /картаа сугалсан/ бол түүнийг хуралдааны ирцэд оруулж тухайн асуудлаар санал хураахад эсрэг санал өгсөнд тооцно.” гэсний дагуу бүртгэлээсээ гарсан ч “эсрэг” санал өгснөөр тооцох эрсдэлтэй байна.

Үндсэн хуулийн цэц 2025 оны 08 дугаар дүгнэлтийн үндэслэх хэсэгтээ “Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 7 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүд саналаа илээр гаргаж асуудлыг шийдвэрлэнэ. ...” гэж асуудлыг гишүүд саналаа гаргаж шийдвэрлэх буюу идэвхтэй үйлдэл хийснээр санал тоологдох тухай зохицуулсан байна. Улсын Их Хурлаас аливаа шийдвэр гаргахад зөвхөн санал өгсөн гишүүний тоог тоолох нь Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэх зарчимд илүү нийцнэ. Бусад ардчилсан улсад ирцэд орсон ч санал өгөөгүй гишүүнийг эсрэг санал өгсөнд тооцдог практик тогтоогдохгүй байна.”¹ гэж дүгнэсэн.

2020 оноос хойш ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ мэдэгдэж санал хураалтад оролцоогүй гишүүдийн лавлагааг Улсын Их Хурлын Тамгын газраас гаргуулахад энэ хугацаанд гишүүн өөрөө мэдэгдэж санал хураалтад оролцоогүй тохиолдол зөвхөн хоёр удаа гарснаас нэг удаад нь тухайн гишүүнийг эсрэг санал өгснөөр тооцжээ. Зүй нь ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ мэдэгдэж санал хураалтад оролцоогүй гишүүнийг ирцэд нь оруулан тооцох боломжтой байх ёстой юм. Энэхүү зохицуулалт хэрэгжсэнээр Улсын Их Хурлын гишүүн санал өгөх бүрэн эрхээ хөндлөнгийн нөлөөлөлгүй, хараат бусаар эдлэх боломж бүрдэж, чуулганы хуралдааны ирц нэмэгдэх эерэг үр дагавар гарна.

6.Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн, Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны хуралдааныг зохион байгуулахдаа хэлэлцэж буй асуудлаар парламентын гишүүдийн байр суурийг хурлын тэмдэглэлд тусгаж, баримтжуулж үлдээх нь парламент нээлттэй, ил тод байх, цөөнхийн саналыг хүндэтгэн асуудлыг олон талт үзэл бодлын үүднээс чөлөөтэй хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэх зарчмыг хэрэгжүүлэхэд чухал нөлөөтэй гэж үзэж байна. Тэгвэл одоо хэрэгжиж буй Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 135 дугаар зүйлд

¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17433600279452>

заасан хуралдааны товч тэмдэглэлд ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ мэдэгдэн санал хураалтад оролцоогүй гишүүний талаар тухайлан тэмдэглэж баримтжуулах зохицуулалтыг тусгаснаар дээрх зарчмын хэрэгжилтийг бодитой хангах, парламентын түүхийг илтгэн харуулдаг хуралдааны тэмдэглэл боловсронгуй болж хөгжих эерэг үр дагавар авчирна гэж үзэв.

Иймд дээрх хууль зүйн үндэслэл, практик шаардлагад нийцүүлэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон түүнийг дагалдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 4 зүйлтэй байхаар боловсруулна.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд Улсын Их Хурлын гишүүдийн хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг Улсын Их Хурлын цахим хуудаст нээлттэй байршуулж, мэдээлэх, чуулганы хуралдааны өмнө болон чуулганы хуралдааны явцад тодорхой хэлэлцэж буй асуудлын талаар ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ мэдэгдсэн бол тухай бүр уг бүртгэлд оруулж, нийтэд нээлттэй мэдээлж байхаар тусгана.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлд тухайн асуудлаар ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзвэл хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллахгүй байх асуудлыг гишүүний үйл ажиллагаанд хориглохоор тусгана.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлд тухайн асуудлаар зөвхөн гэр бүлийн гишүүдээр хязгаарлахгүйгээр хамаарал бүхий этгээд нь ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзвэл хэлэлцүүлэг, санал хураалтад оролцохоос татгалзах асуудлыг тусгана.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд хуулийг хүчин төгөлдөр дагаж мөрдөж эхлэх хугацааг зохицуулна.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар

126 гишүүний бүрэлдэхүүнтэй Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагааг асуудлыг ардчилсан, шударга зарчмаар, ашиг сонирхлын зөрчлөөс ангид явуулахад хуулийн төслийн үндсэн зорилго оршиж буй тул уг хуулийн төсөл болон дагалдуулан боловсруулсан хуулийн төсөл батлагдсанаар парламентын ардчилсан, ил тод байдлыг хангах, гишүүдийг ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах, Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагаа илүү боловсронгуй, хэлэлцүүлгийн горим ойлгомжтой, тодорхой болох эерэг үр дүн гарна.

Түүнчлэн хууль тогтоох үйл ажиллагаанд оролцох Улсын Их Хурлын гишүүдийн ирц, идэвх, оролцоо, сахилга, хариуцлага нэмэгдэж, ард түмний засаглах эрхийг бодитой хангахад эерэг нөлөө үзүүлнэ.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын

**олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг
хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах,
хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар**

Уг хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Авилгын эсрэг НҮБ-ын конвенц болон бусад хууль тогтоомжид нийцсэн болно.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” УИХ-ын тогтоолын төслийн хамт Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулна.

Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” УИХ-ын тогтоолын төслийн тухайд “Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн баталсан Улсын Их Хурлын тогтоолыг одоогийн Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зохицуулалтад нийцүүлж нэр томьёо, хууль зүйн техникийг засварлахаар тусгана.

—oOo—

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Нэг. Хуулийн төслийн ерөнхий агуулга, зохицуулах харилцаа

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.3-т “гишүүний нэр хүнд, бүрэн эрхийг хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглах;”-ыг хориглосон бол Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1-т “Гишүүн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, улс төрийн үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх нөхцөлийг баримталж ажиллана.” гэжээ.

Түүнчлэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т “Албан тушаалтан албаны бүрэн эрхээ хувийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн зорилгод ашиглахгүй бөгөөд албан үүрэгт нь нөлөөлөхүйц аливаа харилцаанаас ангид байна.”, мөн зүйлийн 6.4-т “Албан тушаалтан ашиг сонирхлын зөрчилд орж болохуйц нөхцөл байдлыг мэдэгдэх, түүнээс татгалзах замаар урьдчилан сэргийлнэ.” гэж тус тус заасан. Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн Зорилт 2.4-т “Төрийн өндөр албан тушалатан, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтныг ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэсэн болно. Мөн Монгол Улсын нэгдэн орсон Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 5 дугаар зүйлийн 3-т “Оролцогч улс бүр авилгалаас урьдчилан сэргийлж, тэмцэхэд нийцэхүйц байдлыг тодорхойлох зорилгоор холбогдох эрх зүйн баримт бичиг болон захиргааны арга хэмжээнд тогтмол дүгнэлт хийж байхыг чармайна.” гэсэн болно.

Парламент нийгмийн хөгжлийн үндсэн асуудлыг ардчилсан зарчмаар шуурхай шийдвэрлэхийн тулд өөрийн үйл ажиллагааныхаа үр өгөөжийг дээшлүүлэх, тухай бүр боловсронгуй болгож байх ёстой институци, төрийн эрх барих дээд байгууллагын хувьд бусад байгууллагын хувьд үлгэр жишээ байх учиртай. Иймд цаг үеийн хэрэгцээ, шаардлагыг тогтмол шинжлэн судлах, түүнд үндэслэн хууль тогтоомжийн төслийн санал боловсруулах урт хугацааны санах ой бүхий байнгын тогтолцоог бүрдүүлэх нь Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөнд туссан томоохон зорилт тул Улсын Их Хурлын гишүүн ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зохицуулалтыг илүү тодорхой болгож, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн хэрэглээг боловсронгуй болгох нь зүйтэй гэж үзсэн.

Хоёр.Хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төсөлд тусгасан зарчмын шинжтэй зохицуулалт

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь дөрвөн зүйлтэй бөгөөд хуулийн төсөлд тусгасан зарчмын шинжтэй зохицуулалтыг дэлгэрэнгүй танилцуулгад оруулсан.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 10.1.1-д заасны дагуу боловсруулж, хуулийн төслийг боловсруулах шатанд дотоодын болон гадаад улс орнуудын хууль тогтоомжийг судалсан.

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Хууль тогтоомжийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжтой нийцсэн болно.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

--oOo--

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн холбогдох зохицуулалтын тайлбарыг гаргав. Үүнд:

1.Нэмэлт, өөрчлөлт оруулах, өөрчлөн найруулах, үг өгүүлбэрийг хасах, хүчингүй болсонд тооцох болсон үндэслэл, шаардлага

Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, хэсэг	Үндэслэл, шаардлага
1 дүгээр зүйл буюу хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмэх болсон үндэслэл, шаардлагын талаар	
1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 38.4, 38.5 дахь хэсэг нэмсүгэй: “38.4.Улсын Их Хурлын гишүүний хувийн ашиг сонирхол, хөрөнгө, орлогын талаарх доорх мэдээллийг Улсын Их Хурлын цахим хуудаст нээлттэй байршуулна: 38.4.1.Улсын Их Хурлын гишүүний Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авилгын эсрэг хуульд заасны дагуу гаргасан хувийн ашиг сонирхол, хөрөнгө, орлогын мэдүүлэг; 38.4.2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10.10, 10.11-т заасны дагуу гишүүний гаргасан мэдэгдэл. 38.5.Энэ хуулийн 38.4.1-т заасан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан	38.4 дэх хэсгийн тухайд: Дэлхийн ихэнх улс орны парламент үйл ажиллагааны ил тод, “шилэн” байдлаа хангахын тулд өөрийн гишүүдийн ашиг сонирхлын мэдүүлэг, бүртгэлийг тогтмол хөтөлж хэвшсэн. Тухайлбал, ИБУИНВУ-ын парламентад Ашиг сонирхлын бүртгэл (Register of Interests) тогтмол хөтөлдөг бөгөөд тухайн чуулганаар хэлэлцэж буй асуудлын талаар гишүүдийн хийсэн мэдэгдэл, тухайн гишүүний цалин хөлс, шагнал, урамшуулал, гадаад, дотоод томилолтод зарцуулсан зардал зэргийн талаар тогтмол мэдээлж хэвшжээ. Евро парламент өөрийн гишүүдийн Санхүүгийн ашиг сонирхлын бүртгэл (Register of Members’ Financial Interests)-ийг тогтмол хөтөлдөг бөгөөд уг бүртгэл парламентын албан ёсны вэб хуудаст нээлттэй байршдаг. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг нээлттэй байна.”, 25.2-д “Энэ хуулийн 24.1-д заасан байгууллага, албан тушаалтан иргэдийг албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэгтэй саадгүй танилцах боломжоор хангах үүрэгтэй.” гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүдийн хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, мөн тухайн хэлэлцэж байгаа асуудалтай шууд холбоотой үйл ажиллагааны үр дүнд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээд орлого олж байгаа, эсхүл бусад

сэргийлэх тухай хуулийн 24.1.1, Авлигын эсрэг хуулийн 11.1.1-д заасны дагуу Авлигатай тэмцэх газар, 38.4.2-т заасан мэдэгдлийг Тамгын газар бүртгэж, хадгална.”	хэлбэрээр ашиг сонирхлын зөрчилтэй тухай гишүүний мэдэгдлийг Улсын Их Хурал өөрийн албан ёсны цахим хуудастаа зэрэг нийтэлж, иргэдийн мэдэх эрхийг хангаж байх нь парламентын үйл ажиллагааны ил тод байдлыг хангахад эерэг үр нөлөөтэй гэж үзэв. Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т “Дараахь албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг тухайн оны 2 дугаар улиралд багтаан цахим мэдээллийн сүлжээнд байрлуулна.” гээд 14.1.2-т “Улсын Их Хурлын дарга, дэд дарга, гишүүн,” гэж заасан. 38.5 дахь хэсгийн тухайд: Улсын Их Хурлын гишүүний Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авилгын эсрэг хуульд заасны дагуу гаргасан хувийн ашиг сонирхол, хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хадгалдаг. Харин Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10.10, 10.11-т заасны дагуу гишүүний гаргасан мэдэгдэл нь парламентын чуулганы хуралдаан явцад тухайн гишүүний өөрийн санаачилгаар буюу тодорхой хэлэлцэж буй асуудлын талаарх ашиг сонирхлын хамаарлаа илэрхийлж буй хэлбэр бөгөөд уг мэдэгдлийг Улсын Их Хурлын Тамгын газарт бүртгэж, хадгалж байхаар зохицуулав. Тодруулбал, энэ төрлийг мэдэгдлийг хуралдааны тэмдэглэлд тусган баримтжуулахын зэрэгцээ тогтмол бүртгэж, хадгалснаар цаашид Улсын Их Хурлаар тухайн гишүүний ашиг сонирхол хөндөгдөхүйц асуудлыг хэлэлцэж байгаа үед тухайлан олон нийтийн мэдэх эрхийг эдлүүлэх, парламентын ил тод байдлыг хангахад чухал дэвшил авчирна гэж үзсэн.
2 дугаар зүйл буюу хуульд оруулсан бусад нэмэлтийн үндэслэл, шаардлагын талаар	
2 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.13 дахь заалтын “ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзвэл” гэсний	Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн дагуу гишүүн тодорхой асуудлаар ашиг сонирхлын зөрчилтэй бол хянан шалгах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орохыг

дараа “хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх,” гэж нэмсүгэй.	хориглосон болно. Ашиг сонирхлын зөрчилтэй гишүүнд тавигдах энэхүү хязгаарлалтыг хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт мөн адил орохгүй байхаар зохицуулах нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.23-т “гишүүн хэлэлцэх гэж байгаа асуудалтай шууд холбоотой үйл ажиллагааны үр дүнд өөрөө болон гэр бүлийн гишүүд нь орлого олж байгаа, эсхүл бусад хэлбэрээр ашиг сонирхлын зөрчилтэй бол тухайн асуудлаар хэлэлцүүлэг, санал хураалтад оролцохоос татгалзах,” тухай гишүүний бүрэн эрхийг бодитой хэрэгжүүлэхэд дэмжлэг болно гэж үзэв.
3 дугаар зүйл буюу хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг өөрчлөн найруулах үндэслэл, шаардлагын талаар	
3 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.23 дахь заалтын “гэр бүлийн гишүүд” гэснийг “хамаарал бүхий этгээд” гэж өөрчилсүгэй.	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т “Албан тушаалтан албаны бүрэн эрхээ хувийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн зорилгод ашиглахгүй бөгөөд албан үүрэгт нь нөлөөлөхүйц аливаа харилцаанаас ангид байна.”, мөн зүйлийн 6.4-т “Албан тушаалтан ашиг сонирхлын зөрчилд орж болохуйц нөхцөл байдлыг мэдэгдэх, түүнээс татгалзах замаар урьдчилан сэргийлнэ.” гэж тус тус заасан. Иймд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан шаардлагад одоогийн зохицуулалтыг нийцүүлж гишүүнийг зөвхөн өөрийг нь болон гэр бүлийн гишүүдээр нь хязгаарлахгүйгээр түүнтэй хамаарал бүхий этгээд буюу нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг хуулийн үйлчлэлд хамааруулах нь зүйтэй байна.
4 дүгээр зүйл буюу хуулийг дагаж мөрдөх журмын талаар	
4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2026 оны намрын ээлжит чуулган нээсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.	Энэхүү хуулийн төслийг 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хэлэлцүүлж, 2026 оны намрын ээлжит чуулган нээсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр боловсруулав.

2.Зохицуулахаар тусгасан харилцааны агуулга, зохицуулалт нь Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан бөгөөд үзэл баримтлалын хүрээнээс гажаагүй болно.

3.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд шинэ нэр томъёо, ухагдахуун оруулаагүй бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэж уг хуулийн төслийг боловсруулсан болно.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

--oOo--

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 38.4, 38.5 дахь хэсэг нэмсүгэй:

“38.4.Улсын Их Хурлын гишүүний хувийн ашиг сонирхол, хөрөнгө, орлогын талаарх доорх мэдээллийг Улсын Их Хурлын цахим хуудаст нээлттэй байршуулна:

38.4.1.Улсын Их Хурлын гишүүний Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авилгын эсрэг хуульд заасны дагуу гаргасан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг;

38.4.2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10.10, 10.11-т заасны дагуу гишүүний гаргасан мэдэгдэл.

38.5.Энэ хуулийн 38.4.1-т заасан мэдүүлгүүдийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24.1.1, Авлигын эсрэг хуулийн 11.1.1-д заасны дагуу Авлигатай тэмцэх газар, 38.4.2-т заасан мэдэгдлийг Тамгын газар бүртгэж, хадгална.”

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.13 дахь заалтын “ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзвэл” гэсний дараа “хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.23 дахь заалтын “гэр бүлийн гишүүд” гэснийг “хамаарал бүхий этгээд” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2026 оны намрын ээлжит чуулганы хуралдаан нээсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн
тухай хуульд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай хуулийн төслийн талаар

Нэг.Хуулийн төслийн ерөнхий агуулга, зохицуулах харилцаа

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.3-т “гишүүний нэр хүнд, бүрэн эрхийг хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглах;”-ыг хориглосон бол Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1-т “Гишүүн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, улс төрийн үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх нөхцөлийг баримталж ажиллана.” гэжээ.

Түүнчлэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т “Албан тушаалтан албаны бүрэн эрхээ хувийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн зорилгод ашиглахгүй бөгөөд албан үүрэгт нь нөлөөлөхүйц аливаа харилцаанаас ангид байна.”, мөн зүйлийн 6.4-т “Албан тушаалтан ашиг сонирхлын зөрчилд орж болохуйц нөхцөл байдлыг мэдэгдэх, түүнээс татгалзах замаар урьдчилан сэргийлнэ.” гэж тус тус заасан. Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн Зорилт 2.4-т “Төрийн өндөр албан тушалатан, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтныг ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэсэн болно. Мөн Монгол Улсын нэгдэн орсон Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 5 дугаар зүйлийн 3-т “Оролцогч улс бүр авилгалаас урьдчилан сэргийлж, тэмцэхэд нийцэхүйц байдлыг тодорхойлох зорилгоор холбогдох эрх зүйн баримт бичиг болон захиргааны арга хэмжээнд тогтмол дүгнэлт хийж байхыг чармайна.” гэсэн болно.

Парламент нийгмийн хөгжлийн үндсэн асуудлыг ардчилсан зарчмаар шуурхай шийдвэрлэхийн тулд өөрийн үйл ажиллагааныхаа үр өгөөжийг дээшлүүлэх, тухай бүр боловсронгуй болгож байх ёстой институци, төрийн эрх барих дээд байгууллагын хувьд бусад байгууллагын хувьд үлгэр жишээ байх учиртай. Иймд цаг үеийн хэрэгцээ, шаардлагыг тогтмол шинжлэн судлах, түүнд үндэслэн хууль тогтоомжийн төслийн санал боловсруулах урт хугацааны санах ой бүхий байнгын тогтолцоог бүрдүүлэх нь Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөнд туссан томоохон зорилт тул Улсын Их Хурлын гишүүн ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зохицуулалтыг илүү тодорхой болгож, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хэрэглээг боловсронгуй болгох нь зүйтэй гэж үзсэн.

Хоёр.Хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төсөлд тусгасан зарчмын шинжтэй зохицуулалт

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь таван зүйлтэй бөгөөд хуулийн төсөлд тусгасан зарчмын шинжтэй зохицуулалтыг дэлгэрэнгүй танилцуулгад оруулсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 10.1.1-д заасны дагуу боловсруулж, хуулийн төслийг боловсруулах шатанд дотоодын болон гадаад улс орнуудын хууль тогтоомжийг судалсан.

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Хууль тогтоомжийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжтой нийцсэн болно.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

--oOo--

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тайлбарыг дараах байдлаар гаргав. Үүнд:

1.Нэмэлт, өөрчлөлт оруулах, өөрчлөн найруулах, үг өгүүлбэрийг хасах, хүчингүй болсонд тооцох болсон үндэслэл, шаардлага

Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, хэсэг	Үндэслэл, шаардлага
1 дүгээр зүйл буюу хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмэх болсон үндэслэл, шаардлагын талаар	
1 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.11 дэх хэсгийг нэмсүгэй: “10.11.Хэрэв энэ хуулийн 10.10-т заасан нөхцөл байдал хуралдааны явцад тогтоогдвол гишүүн энэ тухай хуралдаан даргалагчид мэдэгдэж санал хураалтад оролцохгүй. Энэ тохиолдолд хуралдаан даргалагч тухайн гишүүнд санал хураах төхөөрөмжөө идэвхигүй болгох зөвшөөрөл өгөх ба ирцэд оруулж тооцно.”	Авлигатай тэмцэх газраас гаргасан зөвлөмжид “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэх үүрэгтэй, эрх бүхий байгууллага, албан тушаалтан тухайн албан тушаалтны гаргасан ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүссэн талаарх тайлбар болон ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл, хувийн ашиг сонирхлын мэдүүлэгт үндэслэн тухайн албан үүргийг өөр албан тушаалтнаар гүйцэтгүүлэх эсэх шийдвэрийг нэн даруй бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргах бөгөөд шийдвэр гаргаагүй бол ашиг сонирхлын зөрчилгүй гэж үзсэнд тооцно.” гэжээ. Иймд чуулганы хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудалтай шууд холбоотой үйл ажиллагааны үр дүнд өөрөө болон хамаарал бүхий этгээд нь орлого олж байгаа, эсхүл бусад хэлбэрээр ашиг сонирхлын зөрчилтэй бол энэ тухай хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдэж санал хураалтад оролцохгүй байх үүргээ биелүүлэхэд нь хуралдаан даргалагчийн зүгээс зохих ёсны идэвхитэй

	үйлдэл хийх, гишүүний мэдэгдлийг албажуулах арга хэмжээ авах нь зөв байна.
2 дугаар зүйл буюу хуульд оруулсан бусад нэмэлтийн үндэслэл, шаардлагын талаар	
2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 135 дугаар зүйлийн 135.3.3 дахь заалтын “саналын тоо” гэсний дараа “, энэ хуулийн 10.10, 10.11-д заасны дагуу санал хураалтад оролцоогүй гишүүний тоо” гэж нэмсүгэй.	Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн, Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны хуралдааныг зохион байгуулахдаа хэлэлцэж буй асуудлаар парламентын гишүүдийн байр суурийг хурлын тэмдэглэлд тусгаж, баримтжуулж үлдээх нь парламент нээлттэй, ил тод байх, цөөнхийн саналыг хүндэтгэн асуудлыг олон талт үзэл бодлын үүднээс чөлөөтэй хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэх зарчмыг хэрэгжүүлэхэд чухал нөлөөтэй гэж үзэж байна. Тэгвэл одоо хэрэгжиж буй Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 135 дугаар зүйлд заасан хуралдааны товч тэмдэглэлд ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ мэдэгдэн санал хураалтад оролцоогүй гишүүний талаар тухайлан тэмдэглэж баримтжуулах зохицуулалтыг тусгаснаар дээрх зарчмын хэрэгжилтийг бодитой хангах, парламентын түүхийг илтгэн харуулдаг хуралдааны тэмдэглэл боловсронгуй болж хөгжих эерэг үр дагавар авчирна гэж үзэв.
3, 4 дүгээр зүйл буюу хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг өөрчлөн найруулах үндэслэл, шаардлагын талаар	
3 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай: “10.10.Гишүүн тухайн хэлэлцэж байгаа асуудалтай шууд холбоотой үйл ажиллагааны үр дүнд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээд орлого олж байгаа, эсхүл бусад хэлбэрээр ашиг сонирхлын зөрчилтэй бол энэ тухай хуралдааны өмнө хуралдаан даргалагчид бичгээр болон цахим хэлбэрээр урьдчилан	3 дугаар зүйлийн тухайд: Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т “Албан тушаалтан албаны бүрэн эрхээ хувийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн зорилгод ашиглахгүй бөгөөд албан үүрэгт нь нөлөөлөхүйц аливаа харилцаанаас ангид байна.”, мөн зүйлийн 6.4-т “Албан тушаалтан ашиг сонирхлын зөрчилд орж болохуйц нөхцөл байдлыг мэдэгдэх, түүнээс татгалзах замаар урьдчилан сэргийлнэ.” гэж тус тус заасан.

мэдэгдэж санал хураалтад оролцохгүй.” 4 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.11, 10.12, 10.13 дахь хэсгийн дугаарыг “10.12, 10.13, 10.14” гэж, 10.13 дахь хэсгийн “10.11” гэснийг “10.12” гэж, 135.3.5 дахь заалтын “гишүүний” гэснийг “энэ хуулийн 10.10, 10.11-д заасны дагуу санал хураалтад оролцохгүй тухай гишүүний мэдэгдэл болон” гэж тус тус өөрчилсүгэй.	Иймд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан шаардлагад одоогийн зохицуулалтыг нийцүүлж гишүүнийг зөвхөн өөрийг нь болон гэр бүлийн гишүүдээр нь хязгаарлахгүйгээр түүнтэй хамаарал бүхий этгээд буюу нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг хуулийн үйлчлэлд хамааруулах нь зүйтэй байна. 4 дүгээр зүйлийн тухайд: Холбогдох хэсэг нэмэгдэж байгаатай холбогдуулан зүйл, хэсгийн дугаарлалтыг тэдгээрт нийцүүлэн өөрчлөхөөр тусгасан ба чуулганы хуралдааны товч тэмдэглэлд санал хураалтад оролцохгүй тухай гишүүний мэдэгдлийг тусгайлан тэмдэглэж байхаар оруулав.
5 дугаар зүйл буюу хуулийг дагаж мөрдөх журмын талаар	
5 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.	Энэхүү хуулийн төслийг 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хэлэлцүүлж, 2026 оны намрын ээлжит чуулган нээсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр боловсруулав.

2.Зохицуулахаар тусгасан харилцааны агуулга, зохицуулалт нь Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан бөгөөд үзэл баримтлалын хүрээнээс гажаагүй болно.

3.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд шинэ нэр томьёо, ухагдахуун оруулаагүй бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэж уг хуулийн төслийг боловсруулсан болно.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

--оОо--

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.11 дэх хэсгийг нэмсүгэй:

“10.11.Хэрэв энэ хуулийн 10.10-т заасан нөхцөл байдал хуралдааны явцад тогтоогдвол гишүүн энэ тухай хуралдаан даргалагчид мэдэгдэж санал хураалтад оролцохгүй. Энэ тохиолдолд хуралдаан даргалагч тухайн гишүүнд санал хураах төхөөрөмжөө идэвхигүй болгох зөвшөөрөл өгөх ба ирцэд оруулж тооцно.”

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 135 дугаар зүйлийн 135.3.3 дахь заалтын “саналын тоо” гэсний дараа “, энэ хуулийн 10.10, 10.11-д заасны дагуу санал хураалтад оролцоогүй гишүүний тоо” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“10.10.Гишүүн тухайн хэлэлцэж байгаа асуудалтай шууд холбоотой үйл ажиллагааны үр дүнд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээд орлого олж байгаа, эсхүл бусад хэлбэрээр ашиг сонирхлын зөрчилтэй бол энэ тухай хуралдааны өмнө хуралдаан даргалагчид бичгээр болон цахим хэлбэрээр урьдчилан мэдэгдэж санал хураалтад оролцохгүй.”

4 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.11, 10.12, 10.13 дахь хэсгийн дугаарыг “10.12, 10.13, 10.14” гэж, 10.13 дахь хэсгийн “10.11” гэснийг “10.12” гэж, 135.3.5 дахь заалтын “гишүүний” гэснийг “энэ хуулийн 10.10, 10.11-д заасны дагуу санал хураалтад оролцохгүй тухай гишүүний мэдэгдэл болон” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар...

Улаанбаатар
хот

ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 105 дугаар тогтоолын хавсралтын 6.1, 10.3, 10.10, 11.3, 11.4, 12.1 дэх хэсэгт “Ёс зүй, сахилга хариуцлагын” гэснийг “Төрийн байгуулалтын” гэж тус тус өөрчилсүгэй.

2.“Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 105 дугаар тогтоолын хавсралтын 4.12 дахь хэсэгт “сайн дураараа” гэснийг хассугай.

3.Энэ тогтоолыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг